УЛС ТӨР ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

ХЯТАДАД МАРКСИЗМ ЛЕНИНИЗМ ТҮГЭН ДЭЛГЭРСЭН ЗАРИМ ОНЦЛОГ

Д. Баясгалан

Октябрийн социалист их хувьсгал Хятадын олон сая ард түмнийг улс үндсээ чөлөөлөх тэмцэлд уриалсан төдийгүй тэдний ухамсартай хувьсгалт идэвхийг нь өрнүүлсэн юм. Октябрийн хувьсгалын нөлөөгөөр эрч хүчээ авсан Хятадын ард түмний үндэсний чөлөөлөх хөдөлгөөн нь үндэсний хөрөнгөтөн, сэхээтэн, жижиг хөрөнгөтөн, аж үйлдвэрийн пролетари нарын зэрэг нийгмийн өргөн давхаргааг хамарч байжээ.

Нийгмийн сэтгэл зүй, улс төрийн байдал, ирээдүйн хандлага гэх мэт нийгэм, улс төрийн хүчин зүйлүүдээс шалтгаалж эдгээр давхаргуудын амьдралын эрх ашиг сонирхол олон янзаар тодорхойлогдож байв.

Эрх ашиг, сонирхол нь Ф. Энгельсийн хэлснээр, юуны өмнө «Тухайн нийгэм бүрийн эдийн засгийн харилцаанууд»[1]-аар илэрч байдаг билээ. Хувьсгалын өмнөх хятадын нийгмийн бүтэц нь бүхэлдээ шилжилтийн шинжтэй эдийн засгийн хөгжлийн түвшин дорой байсан ба үүнтэй уялдан орчин үеийн ангиуд бүрэлдэх процесс удааширч нийгмийн үе давхаргуудын ялгаа мэдэгдэхүйц болсон байв. Цөөн тоотой байсан хятадын пролетари нар энэхүү олон янзын үе давхаргыг өөрийн сонирхолд нийцүүлэхэд бүрэн бэлэн бус байсан ч хувьсгалт хөдөлгөөнд татагдан оролцоход нь зохих үүрэг гүйцэтгэсэн юм. Хятадын үндэсний ардчилсан хувьсгалын бүх л үеийн туршид пролетари бус давхаргууд ХКН-ын үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлжээ ХКН, хувьсгалт тэмцлийн бүх л үедээ Хятадын хувьсгалын үндэсний шинж чанарыг удирдлага болгон, улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээх, Хятадын сэргэлт хөгжилтийн төлөө үндэсний нэгдмэл зорилтыг удирдлагаа болгосон юм.

ХКН-ын олон түмний баазыг бүрэлдүүлж байсан давхаргуудыг таван үндсэн ангид хуваан үздэг ба үүний нэг нь пролетари ангийн эрх ашиг сонирхол байв. Хятадын пролетари нарын ангийн эрх ашиг, сонирхол нь нэгдмэл байж, капиталистуудтай тэмцэх, өөрийгөө чөлөөлөх нөхцөлийг бүрдүүлэх[2] явдалд оршиж байсан ба энэ нь шинжлэх ухааны социализмын үзэл санаа түгэн дэлгэрэх нэгэн чухал нөхцөл болжээ.

Хятадын пролетари ажилчдын ухамсарт буюу нийт дарлагдагч давхаргын ухамсарт хөрөнгөтний болон жижиг хөрөнгөтний үзэл суртал буюу юуны өмнө үндсэрхэг үзэл санаа зонхилж байв. Энэ нь «хөрөнгөтний үзэл суртал өөрийн үүсэл гарлаараа социалист үзэл суртлаас арай эртнийх байдаг ба илүү боловсронгуй болсон байдлаараа түгэн дэлгэрэх томоохон хэрэгслийг эзэмшсэн байдаг»[3] ерөнхий шалтгаанаас гадна ихээхэн хоцрогдсон оронд тогтвортой байдаг «үндэсний хувиа хичээх, үндэсний хязгаарлагдмал байдал зэрэг жижиг хөрөнгөтний үзлийн хэлбэрүүд»[4] тухайн үеийн хятад оронд оршин байсантай холбоотой юм. Нөгөө талаар коммунист гэсэн нэр хүлээж байгаа ч коммунизмын зорилгыг ойлгоогүй үндэсний ба нийгмийн хувьсгалын зорилтыг сонгоогүй хүмүүс тухайн үед Хятадад олон байв. Тосгон дахь бослогын явцад хөдөө тосгоноос бөөнөөрөө ХКН-д элссэн тариачид, газрын эзэд 20-иод оны сүүлч болоод байхад ч комму-

низм бол шашны шинэ сургаал, түүнийг сохроор дагавал буруудна гэсэн ойлголттой байжээ. Жишээ нь: ХКН-ын VI их хурлын материалд тэмдэглэснээр «Зарим тариачид бослогын үед коммунист нам мандтугай! гэсэн зурагт хуудас бариад түүнийхээ яг өмнө бурхныг дүрсэлсэн байжээ».[5] Энэ бүхнээс авч үзэхэд, 20-иод онд Хятадын пролетари нар өөрийн ангийн ашиг сонирхлыг бүрэн ухамсарлаж чадаагүй ба энэ байдал нь Хятад оронд марксизм ленинизм түгэн дэлгэрэх явцад тодорхой бэрхшээл учруулж байв. Ийм нөхцөлд ХКН-д марксист-ленинист чиглэл бүрэлдэн бий болоход нь В. И. Ленин болон коминтерн онол, практикийн асар их дэмжлэг туслалцааг үзүүлсэн ба түүний нөлөөгөөр Хятадын ард түмний тэргүүний хэсэг үзэл суртал онолын мэдлэгтэй, марксист үзэл санаагаар зэвсэглэсэн отряд болж байв. В. И. Ленин дэлхийд анхны социалист төр байгуулагдсан эхний өдрүүдээс эхлэн дорно дахины асуудалд болон түүний дотор Хятадын асуудалд ихээхэн анхаарал тавьж байлаа. 1917 оны 11-р сард В. И. Лениний заалтаар Зөвлөлт Засгийн газар Петрградад сууж байсан Хятадын элчингээр дамжуулан 1896 оны орос-хятадын гэрээг, 1901 оны Бээжинд байгуулсан (боксерын) протоколыг, түүнчлэн Хятадын асуудлын талаар 1907—1916 онуудад Японтой байгуулсан Хаант Оросын бүх хэлэлцээрийг хүчингүй болгох тухай хэлэлцээ хийж, улмаар хоёр этгээдийн тэгш эрх, улс түмний бүрэн эрхийг харилцан хүндэтгэх үндсэн дээр шинэ гэрээ байгуулах саналыг Хятадын засгийн газарт тавьсан юм.

В. И. Лениний үзэл санааг Хятадад нэвтрэхэд империалист эрх баригч талынхан саад, бэрхшээл учруулах гэж хичнээн оролдсон ч Октябрийн хувьсгалын хувьсгалжуулагч их үзэл санаа Хятадын дэвшилттэй олон нийтэд улам их хүчтэй нөлөөлж марксизм ленинизм түгэн дэлгэрэх нөхцөлийг бүрдүүлж байв.

ХКН-ыг үндэслэгчдийн нэг Ли Дажао: «Большевизмыг судалж ард түмнийг түүнтэй танилцуулах, ард түмэнд түүний тухай үнэнийг ярьж өгөх»[6] хэрэгтэй гэж уриалж байв.

В. И. Лениний санаачлага, удирдлагаар байгуулагдсан Коммунист Интернационал тус орныг үндэс, нийгмийн талаар чөлөөтэй болгох шинэ замыг зааж Хятадад хувьсгалт үзэл санааг дэлгэрүүлж, хувьсгалт хөдөлгөөнийг хөгжүүлэх, ХКН байгуулахад асар их үүрэг гүйцэтгэсэн юм. В. И. Ленин, Коминтерны II их хурал дээр (1920 онд) хэлсэн үгэндээ дорно дахины орнуудын хувьсгалт хөгжлийн замын тухай программын үндэслэлийг томъёолж «Тэргүүний орны пролетари нарын тусламжтайгаар хоцрогдсон орнууд капиталист хөгжлийн шатыг алгасан коммунизмд хүрч чадна[7] гэсэн дүгнэлтээ хийсэн юм. В. И. Лениний дэвшүүлсэн энэ дүгнэлт нь Коминтерний II, IV, VII бага хурлын ба коминтерний гүйцэтгэх хорооны бүгд хурлууд, нарийн бичгийн дарга нарын хуралдааны материалуудад тодорхой тусгагдсан байдаг билээ. Коминтерн, Хятадын хувьсгалд программын ач холбогдол бүхий онол, улс төрийн үндсийг боловсруулж өгөхийн зэрэгцээгээр Хятадын тархай бутархай марксист дугуйлангууд, саланги тусгай хувьсгалт бүлгүүдэд зохион байгуулалт, үзэл санааны их тусламж үзүүлсэн юм.

1920 онд Коминтерний шууд туслалцаатайгаар Хятадад анхны коммунист бүлгүүд байгуулагдаж, анхны коммунист хэвлэл болсон «Синь Циннянь» сэтгүүлд эд материалын тусламж үзүүлж байв. 1920 онд Хятадад Коминтерний төлөөлөгчдийг хүрэлцэн очихын хамт урьд тархай бутархай байсан дугуйлангуудыг нэгтгэх үндсэн дээр ХКН-ыг байгуулах бэлтгэл ажил өрнөсөн юм.

1921 онд анхдугаар их хурлыг зарлан хуралдуулж, Хятадад зохион байгуулалттай коммунист хөдөлгөөний эх суурийг тавьсан юм. Коминтерн, ХКН-ын эхний хурлууд дээр ХКН-ын улс төр, үзэл суртал, зохион байгуулалтын үйл ажиллагааны үндэс болсон программ, дүрмийн зарчмуудыг боловсруулахад практик туслалцааг үзүүлж байв.

Коминтерний IV их хурлаас дорнодахины асуудлын талаар гаргасан сэдвүүдийг дэлгэрүүлэн Хятадын нөхцөлд тохируулан 1923 оны 1-р сарын 12-нд «ХКН-аас гоминьдан намтай харилцах тухай» тусгай тогтоол баталж, түүндээ Хятадад үндэсний нэгдмэл фронт байгуулахын чухлыг үндэслэн, түүнийг хэрэгжүүлэх тодорхой хэлбэрийн хувьд ХКН-ын бие даасан хараат бус байдлыг хэвээр хадгалан коммунистууд гоминьданд элсэн орох саналыг дэвшүүлсэн юм. Ингэснээр ХКН ын нэрт зүтгэлтнүүд гоминьданы үйл ажиллагаанд оролцох болсон ба энэ нь Хятадын хувьсгалт хөдөлгөөнд хүчтэй нөлөөлөх боломжийг ХКН-д олгосон юм.

ХКН, олон түмнийг хамарсан гоминьдан нартай хамтран ажиллах тухай Лениний үзэл санааг нэгдсэн фронт байгуулах зорилгод хэрэгжүүлсэн явдал нь Хятадын хувьсгалын хувь заяанд асар их ач холбогдолтой болсон бөгөөд олон улсын хувьсгалт хөдөлгөөнтэй хувьсгалт Хятадын холбоог бэхжүүлсэн юм.

Колони, хараат орнуудын хувьсгалын зорилтыг тодорхойлохдоо В. И. Ленин газар тариалангийн асуудалд онцгой их анхаарал тавьж байсан ба энэ үзэл санаа ХКН-ын их хурлын шийдвэрийн үндэс болсон юм. Хятадын асуудлаархи В. И. Лениний хийсэн онолын дүгнэлтүүд нь Хятадад марксизм ленинизм түгэн дэлгэрэх үйл явцад асар их ач холбогдлыг үзүүлж байв. В. И. Ленин ба Коминтернээс ХКН-д үзүүлсэн гавьяа нь шинжлэх ухааны социализмын онолтой хятадын хувьсгалын практикийг холбож өгсөнд орших ба энэ үйлсэд Хятадын хувьсгалчид ч ихээхэн хувь нэмрээ оруулсан юм.[8]

ХКН марксист суртал нэвтрүүлгийн чанартай дугуйлангаас олон түмний улс төрийн манлай хүч болсон улс төрийн байгууллагад шилжих шилжилт нь харьцангуй түргэн хугацаанд болжээ. Өөрийн намын бүтэц, бүрэлдэхүүний байдлыг анхааран үзсэний үндсэн дээр ХКН намын дотоодын үзэл суртал хүмүүжлийн ажлыг эрчимжүүлэх явдлыг чухалчлан авч үзэж коминтерний материаллаг ба онолын тусламжид түшиглэн намын сургууль ба сургалтын групп зэрэг боловсрол, соёлын газрыг олноор зохион байгуулжээ.

1923 онд Дэн Жунся, Цюй Цюбо, Жан Тайлэй нарын идэвх санаачилгаар Шанхай Зүүн Өмнөд институтийн бааз дээр түшиглэн их сургуулийг байгуулсан нь 1925 оныг хүртэл Хятадын коммунист боловсон хүчнийг бэлтгэх гол төв болж байв.[9] 1925 оны 9-р сард Ли Дажаогийн санаачилга, ХКН-ын заалтаар Бээжинд намын анхны сургууль байгуулагдсан ба анхны ректор нь Ло Инун, багш нар нь Чжао Шиянь, Чэнь-Циянь нар байв. Энэ сургуульд суралцагчид намын зохион байгуулалт, улс төр, эдийн засгийн ухаан, олон улсын коммунист хөдөлгөөний асуудал зэрэг шинжлэх ухааны коммунизмын онол, арга зүйд суралцаж байв.[10] 1926 оноос ХКН богино хугацаатай (2—3 долоо хоногоос 3 сар хүртэл) намын ажлын курс нээж намын ажилт нуудад марксист-ленинист онолын мэдлэг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулжээ. Ийнхүү коминтерний ба ХКН-ын дэмжлэгтэйгээр марксизмыг сурталчлах намын болон цэргийн олон сургуулиуд ажиллаж эхэлсэн нь намын зохион байгуулалт, үзэл суртал онолын зохих мэдлэгтэй үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд шийдвэрлэх ач холбогдолтой болжээ. Үүний зэрэгцээ коммунист намын гишүүдийг марксист

онолоор зэвсэглэхэд намын hэвлэл чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Зөвхөн 1928 оны дунд үе гэхэд л Хятадын коммунистууд 69 сонин, сэтгүүлийг 14 мужид[11] тарааж байсан ба эдгээр хэвлэлүүдэд марксизм-ленинизмийн сонгодог бүтээлүүдийн орчуулга, марксист утга агуулгатай материалуудыг өргөн нийтлэж байжээ.

Империализмыг эсэргүүцсэн Дорнодахины улс орнуудын болон Хятадын хувьсгалт тэмцэлд онолын талаар гүн гүнзгий мэдлэгтэй, олон түмнийг араасаа дагуулж чадах хувьсгалчид туйлын хэрэгтэй байсан тэр цаг үед буюу 1921 оны 4-р сарын 21-нд Москвад Дорнодахины хөдөлмөрчин түмний их сургууль нээгдэж, удалгүй КУТВ нэрийг олсон[12] ба 1921 оны дундуур КУТВ-т Хятадын 36 хувьсгалчих, 1922 онд 42 хувьсгалчид суралцаж байсан мэдээ байна.[13]

1925 оны 11-р сард Москвад Хятадын үндэсний чөлөөлөх ба коммунист хөдөлгөөний хувьсгалчдыг бэлтгэх зорилгоор их сургуулийг байгуулсан ба хожим нь Сунь-Ятсений нэрэмжит болжээ. Коминтерний ба ХКН-ын зохион байгуулалт, санаачилгаар ЗХУ-д олон арван их, дээд сургуулиудад Хятадын хувьсгалчдыг бэлтгэж байв. 20-40 өөд онд ХКН-д байсан гадаадад боловсрол олсон 118 удирдагчдын 80 хувь нь буюу 70 орчим хувь нь ЗХУ-д боловсрол олсон хүмүүс бай ажээ. Жишээ нь: Бо гу, Ван Мин, Ван Зясян, Жэнь Биши, Линь Боцюй, Ло Инун, Лю-Шаоци гэх мэт хүмүүсийг нэрлэж болох юм.

Хятадад марксист-хувьсгалчдыг бэлтгэх энэхүү ажил нь ХКН-д марксист-ленинист чиглэл давамгайлан хөгжих үзэл санааны нэгэн бодит угтвар түүхэн нөхцөл болсон юм.

Хятадад марксизм түгэн дэлгэрсэн онцлог нь нэлээн эрт үеэс түүхтэй билээ. К. Марксын тухай ба шинжлэх ухааны социализмын тухай анхны мэдээ XIX зууны эцэст Хятад оронд тухайлбал тэргүүний сэхээтнүүдийн хүрээнд хамгийн түрүүнд хүрсэн юм. Гэвч, шинжлэх ухааны социализм тэр үед хятадын ардчилсан үзэлтнүүдэд бусад социалист сургаалуудаас юугаар ч ялгагдахгүй мэт санагдаж байжээ. Энэ тухай 1945 онд ярьсан Мао-Зэдуны дурсамж яриа ч байдаг.[14]

Октябрийн социалист их хувьсгалын хувьсгалжуулагч их нөлөөний ачаар л Хятад оронд марксизм түгэн дэлгэрэх таатай нөхцөл бий болж 1917 оны 10-р сараас 1921 оны 7-р сар хүртэлх богино хугацаанд «Эв хамт намын тунхаг», «Хөлсний хөдөлмөр ба капитал», «Капиталын I дэвтэрийн оршилд», «Дюрингийн эсрэг», «Готын программын шүүмжлэлд», «Философийн гуйланчлал», «Социализм утопиос шинжлэх ухаан болж хөгжсөн нь» зэрэг К. Маркс, Ф. Энгельс нарын 9 бүтээлийг бүрэн эхээр нь ба хэсэгчилсэн байдлаар орчуулан хэвлэжээ. Мөн В. И. Лениний «Пролетари, тариачдын хувьсгалт ардчилсан диктатур», «Их санаачилга», «Пролетарийн диктатурын үеийн улс төр, эдийн засаг», «Төр ба хувьсгал»-ын эхний 2 зүйл гэх мэт 11 бүтээл хятад хэлээр анх хэвлэгджээ.[15] Мөн энэ үед хэвлэгдэх байсан хувьсгалт ардчилсан сэтгүүл «Синь циннянь»-д А. Бебель, В. Л. Луначарский нарын бүтээлүүд болон бусад хэвлэлүүдэд К. Каутский, В. Либкнехт нарын зохиолуудаас нийтлэж байжээ. Түүнчлэн К. Маркс, Ф. Энгельс, В. И. Ленин нарын намтар нэг бус удаа хэвлэгдэж байв.[16] Зөвхөн 1919—1921 оны хоорондох хоёр жилд хэвлэлээр дамжин марксист утга агуулгатай 300 гаруй бүтээл Хятадад нийтлэгдэж байв.[17]

Орос оронд ялсан Октябрийн их хувьсгалын нөлөөгөөр хятад дахь империализм феодализмыг эсэргүүцсэн тэмцэл хүчирхэг түлхэц авч 1919 оны «5-р сарын 4-ний» хөдөлгөөний явцад хятадын нийгмийн тэргүүний хэсэг улс орноо хямралын байдлаас гаргахын чух-

лыг гүнзгий ойлгосон ба Хятадын түүхийн тавцан дээр анх удаа ажилчид гарч тэмцсэн юм. 100 мянга гаруй ажилчид оролцсон энэ хөдөлгөөн марксизм-ленинизмийн үзэл санааны үнэн зөвийн биет баталгаа болжээ.[18]

Хятадад марксизм-ленинизм түгэн дэлгэрэх процессыг түргэтгэсэн өөр нэг чухал хүчин зүйл нь залуу Зөвлөлт улсын эсрэг хийсэн империалистуудын довтолгоон, хувьсгалын эсэргүү бүлэглэлүүдийг бут цохисон явдал юм. Орос оронд болж байгаа энэ үйл явдлын тухай мэдээ Хятадын хувьсгалт ардчилсан хэвлэлүүдийн хуудсанд онцгой байр эзэлж байв.

«Синь циннянь» сэтгүүл 1920 оны 9-р сараас 1921 оны 4-р сар хүртэлх 8 сарын хугацаанд Зөвлөлт улсад болж буй хувьсгалт хөдөлгөөн, эдийн засаг, соёлын байгуулалтын тухай 137 өгүүлэл, тэмдэглэл нийтэлжээ.[19] Мөн тэр үед Хятадын сэхээтнүүдийн дунд Джон Ридийн «Дэлхийг донсолгосон 10 өдөр» ном ихэд алдаршиж байв. Ийнхүү Хятадад марксизм түгэн дэлгэрсэн явдал нь Октябрийн хувьсгалын шууд үргэлжлэл болж ХКН байгуулагдан хөгжих ба марксист ленинист чиглэл давамгайлах түүхэн нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Гэвч Хятадад марксизм ленинизм дэлгэрэх түүхэн явц шулуун дардан замаар явсангүй ээ. Марксист утга зохиол хангалтгүй, дутмаг байсан зэрэг зарим бэрхшээлтэй тулгарч байв. Тухайлбал 20-иод онд Хятадын хувьсгалчид марксизм-ленинизмийн сонгодог бүтээлүүдийг хэсэг бүлгээр нь орчуулгаар дамжуулан уншиж байсан тул энэ шинэ сургаалыг бүрэн төрхөөр нь нийтэд хүргэн, судлах боломжгүй байв. Хятадын залуучуудын Хэвлэл «Жунго Циннянь» сэтгүүл 1924 оны 3-р сарын дугаартаа «Марксын сургаалыг Хятадад одоогийн хэвлэгдэж байгаагаар нь судлах бараг бололцоогүй байна[20] гэж тэмдэглэжээ. Зөвлөлтийн эрдэмтэд орчуулагчдын туслалцаатайгаар К. Маркс, Ф. Энгельс, В. И. Ленин нарын зонхилох зохиол бүтээлүүд хятад хэлээр 30-аад онд орчуулагдсан[21] ба ЗХУ-аас ч марксист зохиолуудаас орчуулан хятадад илгээж байв. Гэвч 30—40-өөд оны үед ч ХКН-ын гишүүд марксизм-ленинизмийн зохиол бүтээлүүдээр бүрэн хангагдаж чадаагүй юм.

Өөр нэгэн бэрхшээлтэй тал нь Хятадад марксист-ленинист онол түгэн дэлгэрэх явдал пролетарийн болон пролетари бус урсгал хэлбэрүүдийн хоорондын үзэл санааны хурц тэмцэл дунд явагдаж иржээ.

Гэвч, Хятадад марксист-ленинист үзэл санаа хөгжсөн үйл явц нь тодорхой бэрхшээлүүдтэй тулгарч байсан ч ХКН-ын эгнээнд байсан тууштай хувьсгалчдын хүч чармайлтын дүнд энэхүү суут сургаал түгэн дэлгэрсэн нь хожмоо Хятадад ардчилсан хувьсгал ялах, улмаар социалист хөгжлийн замаар замнах үйлсийн онолын найдвартай зэвсэг болсон билээ.

1. К. Маркс, Ф. Энгельсийн зохиолын эмхэтгэл, 18-р боть, 271-р тал
2. В. И. Ленин, Зохиолын эмхэтгэл, 6-р боть, 362-р тал
3. Мөн тэнд, 41-р тал
4. Мөн тэнд, 41-р боть, 168-р тал
5. ХКН-ын VI их хурлын материал. М., 1930, IV дэвтэр, 20-р тал
6. Синь Циньнян. 1918., № 53-р тал
7. В. И. Ленин, Зохиолын 31-р боть, 203-р тал
8. Новая и новейшая история. 1982, № 2, 23-44-р тал
9. М. Ф. Юрьев. 1925—1927 оны Хятадын хувьсгал, М. 1968, 110-111-р тал
10. «Синь шици»., 1981, № 11, 27-р тал
11. ХКН-ын VI их хурлын материал. М., 1930, 14-р тал
12. Жизнь национальностей. 1921—5—14 Под знаменем Ильича, 1926—5-8
13. Зян Цанху, Шинэ орос оронд аялсан тухай тэмдэглэл. Шанхай. 1923, 50-р тал